

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



АНД ЭНЕРГИ ХК

Хувьцаат компани

2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр

дуусгавар болсон жилийн

санхүүгийн тайлан

Улаанбаатар хот, 2023 он

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АНД ЭНЕРГИ ХК

(Монгол улсад бүртгэлтэй компани)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31

**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН
АГУУЛГА**

ХУУДАС

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	4
ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРЛАГЫН МЭДЭГДЭЛ	5
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	6-7
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	11
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	12-25

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

: Ц.Гүррагчаа

АЛБАН ЁСНЫ ХАЯГ

: Орхон аймаг, Баян-Өндөр сум, 21-р баг, Уртын гол, баянзам 3, 4, 6 тоот

ХАРИЛЦАГЧ БАНК

: Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Хаан банк

Аудиторууд

:СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

АНД ЭНЕРГИ ХК (цаашид компани гэнэ)-ийн гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа би энэхүү хавсралтад үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг батламжилж байна.

Ц.Гүррагчаа

Ч.Саранзаяа

Улаанбаатар хот, монгол улс

Огноо:



“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ”ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо:2023-02-16

№ 23/04

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АНД ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн АНД ЭНЕРГИ ХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар АНД ЭНЕРГИ ХК компанийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудитуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал

Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот

Утас: 976 – 9904 6494; 86030388

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

Тэмдэглэл

21.12.31

22.12.31

ХӨРӨНГӨ

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгө	4	13,288,511.33	9,857,928.02
Дансны авлага	5	299,802,716.70	630,103,151.61
Татвар ба НДШ-ийн авлага	6	488,283.00	575,153.54
Бусад авлага	7	2,481,536.95	65,423,403.10
Бараа материал	8	349,216,729.56	560,936,099.26
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9	214,732,737.56	60,287,115.17

Эргэлтийн хөрөнгийн дүн

880,010,515.10

1,327,182,850.70

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө	10	1,667,908,733.11	1,571,727,566.43
Биет бус хөрөнгө	11	67,220,278.84	65,788,083.83
Биологийн хөрөнгө	12	6,500,000.00	6,500,000.00

Үндсэн хөрөнгийн дүн

1,741,629,011.95

1,644,015,650.26

Нийт хөрөнгө

2,621,639,527.05

2,971,198,500.96

ӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

ӨР ТӨЛБӨР

Дансны өглөг	13	24,070,127.08	90,529,970.39
Татварын өр	14	19,185,426.28	55,920,708.15
НДШ-н өглөг	15	26,249,420.95	10,294,698.62
Богино хугацаат зээл	16	51,247,472.37	469,322,129.93
Хүүний өглөг	17	434,036.86	3,132,505.07
Урьдчилж орсон орлого	18	22,486,520.00	2,112,480.00
Урт хугацаат зээл	19	406,213,991.47	241,683,706.60

Өр төлбөрийн дүн

549,886,995.01

872,996,198.76

ЭЗДИЙН ӨМЧ

Хувийн өмч	20	78,070,758.00	78,070,758.00
Нэмж төлөгдсөн капитал	21	1,470,540,877.00	1,470,540,877.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22	264,224,371.82	264,224,371.82
Хуримтлагдсан ашиг		258,916,525.22	285,366,295.38

Эздийн өмчийн дүн

2,071,752,532.04

2,098,202,302.20

Нийт эздийн өмч ба өр төлбөр

2,621,639,527.05

2,971,198,500.96

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

Үзүүлэлт	Тэмдэглэл	21.12.31	22.12.31
Борлуулалт	23	2,030,853,671.20	2,084,776,060.63
ББӨ	24	1,266,555,649.99	1,400,284,283.13
Нийт ашиг		764,298,021.21	684,491,777.50
Бусад орлого	25	16,709,535.45	18,111,719.54
Борлуулалт, маркетингийн зардал	26	121,180,256.64	132,175,306.34
Ерөнхий ба удирдлагын зардал	27	541,032,819.72	438,777,416.12
Санхүүгийн зардал	28	78,359,247.65	74,790,166.70
Бусад зардал	29	24,813,032.96	28,866,509.27
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	30	654.28	2,864.73
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	31	(198,607.00)	1,433,160.52
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз	32	-	(287,475.73)
Татвар төлөхийн өмнөх ашиг		15,424,246.97	29,142,648.13
Орлогын татварын зардал	33	1,542,424.70	2,914,264.82
Татварын дараах ашиг		13,881,822.27	26,228,383.31
Цэвэр ашиг		13,881,822.27	26,228,383.31

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2022 ОНЫ 12 САРЫН 31

Үзүүлэлт	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	279,569,146.26	2,092,405,153.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(34,534,443.32)	(34,534,443.32)
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	245,034,702.94	2,057,870,709.76
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	13,881,822.27	13,881,822.27
2021 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	258,916,525.21	2,071,752,532.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	221,386.86	221,386.86
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	259,137,912.07	2,071,973,918.89
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	26,228,383.31	26,228,383.31
2022 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	285,366,295.38	2,098,202,302.20

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

	21.12.31	22.12.31
Мөнгөн орлогын дүн	2,189,615,949.70	2,119,212,437.85
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,609,701,411.70	1,303,709,376.58
Бусад мөнгөн орлого	579,914,538.00	815,503,061.27
Мөнгөн зарлагын дүн	2,051,512,325.19	2,332,283,589.55
Ажилчдад төлсөн	247,777,065.90	201,052,385.24
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	82,122,134.30	126,734,625.65
Бараа материал худалдан авахад төлсөн	1,063,031,998.00	1,202,909,839.19
Ашиглалтын зардалд төлсөн	8,818,377.70	24,181.81
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,442,107.70	8,482,512.81
Хүүний төлбөрт төлсөн	77,925,210.80	71,657,661.63
Татварын байгууллагад төлсөн	210,781,974.70	133,903,452.63
Даатгалын төлбөрт төлсөн	1,256,910.00	-
Бусад мөнгөн зарлага	327,356,546.09	587,518,930.59
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	138,103,624.51	(213,071,151.70)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	7,000,000.00	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,000,000.00	-
Мөнгөн зарлагын дүн	76,900,409.00	202,201,673.84
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,285,000.00	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,232,224.00	-
Бусдад олгосон зээл урьдчилгаа	58,383,185.00	202,201,673.84
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(69,900,409.00)	(202,201,673.84)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	722,870,000.00	897,508,935.33
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	722,870,000.00	897,508,935.33
Мөнгөн зарлагын дүн	803,443,658.40	485,666,693.10
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	803,443,658.40	485,666,693.10
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(80,573,658.40)	411,842,242.23
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(12,370,442.89)	(3,430,583.31)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,658,954.22	13,288,511.33
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,288,511.33	9,857,928.02

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Компанийн талаарх мэдээлэл

Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

- LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл
- Цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
- Үйлдвэрлэлийн автоматжуулалт
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

Тухайн тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй болно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Монгол төгрөгөөр тайлагнасан.

НИЙЦЛИЙН МЭДЭГДЭЛ

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГОД ОРОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

НББОУС, СТОУС ба Санхүүгийн тайлагналын Олон улсын тайлбарын хороо (СТОУТХ)-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн ба дараах шинэ болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс нь хэрэглэнэ гэсэн чиглэлтэй. Үүнд:

- СТОУС 9(Нэмэлт өөрчлөлт): Санхүүгийн хэрэглүүрүүд - 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө.

Дансны авлагаас бусад санхүүгийн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр хэмжих ба санхүүгийн хөрөнгүүд нь бодит бус үнэ цэнээр илэрхийлэгдэж байгаа үед ашиг эсвэл алдагдал, өртөгт тусгана. Өр төлбөрийн үзүүлэлтүүдийг дараа үеийн бодит үнээр хэмжиж, ашиг эсвэл алдагдал, хорогдуулалтын зардлаар тусгана.

- СТОУС 22(Нэмэлт өөрчлөлт): Гадаад валютын гүйлгээ ба урьдчилсан тооцоолол - 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө.

Урьдчилсан төлбөрөөс мөнгөн бус өр эсвэл мөнгөн бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт нь уг гүйлгээ гарсан өдрөөр мөнгөн бус хөрөнгө эсвэл мөнгөн бус өр төлбөрийг хүлээн зөвшөөрөгдөхгүй дүнг спот ханшаар тодорхойлон холбогдох хөрөнгө, зардал эсвэл орлогыг урьдчилан тодорхойлохыг энэхүү стандартаар тайлбарласан. Хэрэв хэд хэдэн төлбөр, урьдчилгаа

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

төлбөр байгаа бол аж ахуйн нэгж урьдчилж төлсөн төлбөрийг хүлээн авсан өдөр буюу ажил гүйлгээ гарсан тухайн өдрөөр тооцоолох ёстой.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Валютын ханшийн тэгшитгэл

Компани нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг.

Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлаар тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

(б) Орлого

Эдийн засгийн үр ашиг нь компанид орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон.

Хүүний орлого

Үр ашиг хүүний аргаар аккруэлдэх үед хүүний орлогыг хүлээн зөвшөөрнө.

(в) Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийн бууралт (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт)-ыг үүсгэж буй эдийн засгийн үр ашгийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Ерөнхий болон удирдлагын зардал бусад зардал санхүүгийн зардлыг гаргасан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(г) Орлогын албан татвар

(i) Өнөөгийн орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварыг хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

(ii) Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварыг суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн 2-ын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн өр төлбөрийн аргыг хэрэглэн тооцдог.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогыг албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвилээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол
 - Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү арилах хугацааг толгой компани, хөрөнгө оруулагч хянаж байдаг ба түр зөрүү нь ойрын ирээдүйд арилахгүй байх магадлалтай байгаа бол
- Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол

Хойшлуулсан орлогын албан татварын бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрт хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрт дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

(д) Ажиллагсдын тэтгэмж

i. Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажиллагсдын холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна.

ii. Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын Эрүүл Мэнд, Нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(е) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Компани хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Хөрөнгийг ашиглалтаас хасах эсвэл борлуулах үед тухайн хөрөнгийн үлдэгдэл ба хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн аливаа бууралтыг данснаас хасаж, холбогдох аливаа олз эсвэл гарзыг тайлант хугацааны орлогын тайланд бүртгэнэ.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааг ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Компьютер 3 жил

Тавилга, тоног төхөөрөмж 10 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхээргүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүр хянаж, шаардлагатай бол залруулга хийнэ.

Санхүүгийн хэрэглүүр

i. Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

НББОУС 39-ийн хамрах хүрээнд багтах санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”, “Зээл ба авлага”, “Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших”, “Борлуулахад бэлэн” эсвэл “Үр ашигтай хэвийн хэрэглүүр” гэж ангилна. Компани нь өөрийн хөрөнгө өр төлбөрийн ангиллыг тэдгээрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө тодорхойлно.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Бүх санхүүгийн хэрэглүүр (“Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” биш санхүүгийн хэрэглүүрээс бусад)-ийг анхлан бодит үнэ цэнэ дээр холбогдох гүйлгээний зардлуудыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Зах зээлийн зохицуулалт эсвэл журмаар (хэвийн худалдааны нөхцөлөөр) тогтоосон хугацааны дотор санхүүгийн хөрөнгийг хүргэж өгөх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн худалдан авалт эсвэл борлуулалтын арилжаа хийгдсэн өдөр (энэ нь Компани хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах үүрэг хүлээсэн өдөр юм) хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн хэрэглүүрүүдэд олгосон зээл, авлага, авсан зээл ба зээллэг багтана. Компанид “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”, “Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших”, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

ii. Дараагийн тайлант үеийн хэмжилт

Санхүүгийн хэрэглүүрүүдийг дараагийн тайлант үед хэрхэн хэмжих нь дараах ангиллуудын алинд нь багтаж байгаагаас хамаарна.

Өр төлбөр ба авлага

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Анх хэмжээний дараа эдгээр санхүүгийн хөрөнгүүдийг үр ашигт хүүний аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Санхүүгийн орлого”-д багтана. Зээлийн үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Санхүүгийн зардал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Зээл

Анхны хэмжилтийг өөрчлөх, хүүгүй бусад өглөгүүдийг дараагийн тайлант үед нь хорогдуулсан дүнгээр тооцоолно.

Хорогдуулсан дүнг худалдан авалтын хөнгөлөлт эсвэл урамшууллыг харгалзан тооцоолох ба зээлийн хүүгийн зардал нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн санхүүгийн зардал хэсэгт тайлагнагдана. Зээл нь зээлийн өглөг, зээлийн хүүгийн өглөг, бусад өглөгүүдээс бүрдэнэ.

3. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД

Компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх ажил нь Компаниас хөрөнгө, өр, төлбөр, орлого, зардлууд дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба болзошгүй өр төлбөр болон хөрөнгүүд дээр тодруулга хийхийг шаарддаг.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үнэлэмж

Үйл ажиллагааны мөнгөн нэгжийг тодорхойлох

Компанид хамаарах, холбогдох нөхцөл байдлын эдийн засгийн агуулга дээр үндэслэн Компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгж нь Монгол Төгрөг байна гэж тодорхойлсон.

Компанийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үндсэн орчны мөнгөн нэгж нь Монгол төгрөг ба энэ нь Компанид хамаарах холбогдох гүйлгээ, үйл явдлууд, нөхцөлүүдэд голдуу нөлөө үзүүлдэг мөнгөн нэгж юм.

Санхүүгийн хэрэглүүрийн ангилал

Компанийн санхүүгийн хэрэглүүрүүд эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн гэрээний агуулга, санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэрэглүүр гэж ангилдаг. Санхүүгийн хэрэглүүрийн хуулийн хэлбэрээс нь илүү агуулгыг харж тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд ангилж тайлагнадаг.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2021 MNT	2022 MNT
Касс дахь мөнгө	1,554,099.67	2,657,215.51
Банкин дахь мөнгө	11,734,411.66	7,200,712.51
	13,288,511.33	9,857,928.02

5. ДАНСНЫ АВЛАГА

	2021 MNT	2022 MNT
Дансны авлага	299,802,716.70	630,103,151.61
	299,802,716.70	630,103,151.61

6. ТАТВАРЫН АВЛАГА

	2021 MNT	2022 MNT
НӨАТ-н авлага	-	575,153.54
Бусад татварын авлага	488,283.00	-
	488,283.00	575,153.54

7. БУСАД АВЛАГА

	2021 MNT	2022 MNT
Холбоотой талаас авах авлага	-	19,126,332.00
Ажиллагчдаас авах авлага	1,892,450.00	2,800,350.00
Бусад талуудаас авах авлага	589,086.95	43,496,721.10
	2,481,536.95	65,423,403.10

8. БАРАА МАТЕРИАЛ

	2021 MNT	2022 MNT
Түүхий эд материал	126,313,851.14	192,877,466.99
Дуусаагүй үйлдвэрлэл	11,928,903.06	29,120,248.68
Бэлэн бүтээгдэхүүн	138,875,612.54	262,449,654.72
Хангамжийн материал	72,098,362.82	73,943,274.41
Бусад	-	2,545,454.46
	349,216,729.56	560,936,099.26

9. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

	2021 MNT	2022 MNT
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	214,732,737.56	60,287,115.17
	214,732,737.56	60,287,115.17

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэглэл	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ӨРТӨГ						
Эхний үлдэгдэл	1,478,225,908.80	261,290,308.70	83,272,111.00	132,745,292.60	41,306,397.10	1,996,840,018.20
Нэмэлт	-	4,035,102.23	14,545,454.55	-	900,000.00	19,480,556.78
Хасагдсан	-	-	14,800,000.00	8,193,466.75	-	22,993,466.75
Эцсийн үлдэгдэл	1,478,225,908.80	265,325,410.93	83,017,565.55	124,551,825.85	42,206,397.10	1,993,327,108.23
Хуримтлагдсан элэгдэл						
Эхний үлдэгдэл	135,006,904.26	92,751,778.16	30,879,493.21	38,463,576.94	31,829,532.52	328,931,285.09
Нэмэлт	46,418,100.00	26,271,800.00	8,227,915.43	13,641,850.00	5,828,181.36	100,387,846.79
Хасагдсан	-	-	5,630,016.46	2,089,573.62	-	7,719,590.08
Эцсийн үлдэгдэл	181,425,004.26	119,023,578.16	33,477,392.18	50,015,853.32	37,657,713.88	421,599,541.80
Дансны цэвэр дүн	1,296,800,904.54	146,301,832.77	49,540,173.37	74,535,972.53	4,548,683.22	1,571,727,566.43

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2021 MNT	2022 MNT
Биет бус хөрөнгө	70,548,224.00	67,413,610.86
Хуримтлагдсан элэгдэл биет бус хөрөнгө	(3,327,945.16)	(1,625,527.03)
	67,220,278.84	65,788,083.83

12. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

	2021 MNT	2022 MNT
Биологийн хөрөнгө /Мал сүрэг/	6,500,000.00	6,500,000.00
	6,500,000.00	6,500,000.00

13. ДАНСНЫ ӨГЛӨГ

	2021 MNT	2022 MNT
Дотоодын байгууллагад төлөх өглөг	24,070,127.08	41,231,520.00
Гадаадын байгууллагад төлөх өглөг	-	48,171,009.39
Нооромчлолын сан	-	1,127,441.00
	24,070,127.08	90,529,970.39

14. ТАТВАРЫН ӨР

	2021 MNT	2022 MNT
ААНОАТ өр	988,511.91	1,150,564.62
НӨАТ-н өр	10,994,444.73	46,933,706.19
ХХОАТ-н өр	7,202,469.64	7,836,437.34
	19,185,426.28	55,920,708.15

15. НДШ-Н ӨГЛӨГ

	2021 MNT	2022 MNT
НДШ-н өглөг	26,249,420.95	10,294,698.62
	26,249,420.95	10,294,698.62

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

16. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

	2021 MNT	2022 MNT
Хувь хүмүүст төлөх өглөг	51,247,472.37	204,658,758.00
Банкны богино хугацаат зээл	-	264,663,371.93
	51,247,472.37	469,322,129.93

17. ХҮҮНИЙ ӨГЛӨГ

	2021 MNT	2022 MNT
Хүүний өглөг	434,036.86	3,132,505.07
	434,036.86	3,132,505.07

18. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

	2021 MNT	2022 MNT
Урьдчилж орсон орлого	22,486,520.00	2,112,480.00
	22,486,520.00	2,112,480.00

19. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

	2021 MNT	2022 MNT
Урт хугацаат зээл	406,213,991.47	241,683,706.60
	406,213,991.47	241,683,706.60

20. ЭЗДИЙН ӨМЧ

	2021 MNT	2022 MNT
Эздийн өмч	78,070,758.00	78,070,758.00
	78,070,758.00	78,070,758.00

21. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

	2021 MNT	2022 MNT
Нэмж төлөгдсөн капитал	1,470,540,877.00	1,470,540,877.00
	1,470,540,877.00	1,470,540,877.00

22. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

	2021 MNT	2022 MNT
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	264,224,371.82	264,224,371.82
	264,224,371.82	264,224,371.82

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

23. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2021 MNT	2022 MNT
Борлуулалтын орлого	2,030,853,671.20	2,084,776,060.63
	2,030,853,671.20	2,084,776,060.63

24. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	2021 MNT	2022 MNT
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,266,555,649.99	1,400,284,283.13
	1,266,555,649.99	1,400,284,283.13

25. БУСАД ОРЛОГО

	2021 MNT	2022 MNT
Бусад орлого	16,709,535.45	18,111,719.54
	16,709,535.45	18,111,719.54

26. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

	2021 MNT	2022 MNT
Цалингийн зардал	72,756,215.05	86,217,393.57
Нийгмийн даатгалын шимтгэл	9,543,400.48	-
Албан татвар хураамжийн зардал	9,747,596.39	1,275,200.00
Томилолтын зардал	-	1,818,760.91
Бичиг хэргийн зардал	-	756,475.59
Шуудан холбооны зардал	-	2,384,653.41
Сургалтын зардал	-	223,154.53
Сонин сэтгүүл захиалгын зардал	-	1,357,968.18
Ашиглалтын зардал	-	4,589,187.42
Засвар үйлчилгээний зардал	-	148,904.88
Түрээсийн зардал	6,985,023.05	9,389,540.99
Харуул хамгаалалтын зардал	-	183,021.43
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	-	397,939.51
Тээврийн зардал	1,350,061.88	8,490,512.81
Шатахууны зардал	-	2,110,959.19
Зар сурталчилгааны зардал	20,797,959.79	9,819,654.86
Бусад зардал	-	3,011,979.06
	121,180,256.64	132,175,306.34

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

27. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2021 MNT	2022 MNT
Цалингийн зардал	271,332,928.84	231,913,961.04
Нийгмийн даатгалын шимтгэл	55,635,200.00	63,456,095.78
Албан татвар хураамжийн зардал	1,357,400.00	19,577,923.74
Томилолтын зардал	600,000.00	2,254,919.47
Бичиг хэргийн зардал	4,275,424.00	1,330,305.46
Шуудан холбооны зардал	3,042,220.00	2,693,197.58
Мэргэжлийн үйлчилгээний зардал	8,530,024.30	5,932,200.00
Сургалтын зардал	3,445,999.64	2,812,172.73
Даатгалын зардал	865,200.00	13,305,602.00
Ашиглалтын зардал	7,613,100.00	5,628,358.03
Засвар үйлчилгээний зардал	13,870,900.00	8,124,951.82
Элэгдэл хорогдлын зардал	118,771,662.94	55,182,710.17
Харуул хамгаалалтын зардал	-	341,346.28
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,637,000.00	1,239,543.89
Тээврийн зардал	1,115,100.00	4,495,593.39
Шатахууны зардал	12,342,200.00	3,312,685.39
Хүлээн авалтын зардал	-	148,414.33
Газрын төлбөр	377,760.00	377,760.00
Бусад зардал	35,220,700.00	16,649,675.02
	541,032,819.72	438,777,416.12

28. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2021 MNT	2022 MNT
Хүүгийн зардал	78,359,247.65	74,790,166.70
	78,359,247.65	74,790,166.70

29. БУСАД ЗАРДАЛ

	2021 MNT	2022 MNT
Алданги, торгуулийн зардал	379,236.68	169,197.98
Хандивын зардал	4,622,328.05	4,795,097.30
Найдваргүй авлагын зардал	10,068,771.00	-
Үйл ажиллагааны бусад зардал	938,500.00	23,902,213.99
Баяр ёслол	8,804,197.23	-
	24,813,032.96	28,866,509.27

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

30. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ ГАРЗ

	2021 MNT	2022 MNT
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	654.28	2,864.73
	654.28	2,864.73

31. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ДАНСНААС ХАССАНЫ ОЛЗ ГАРЗ

	2021 MNT	2022 MNT
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	(198,607.00)	1,433,160.52
	(198,607.00)	1,433,160.52

32. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОРЛУУЛСНААС ҮҮССЭН ОЛЗ ГАРЗ

	2022 MNT
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз	(287,475.73)
	(287,475.73)

33. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	2021 MNT	2022 MNT
Орлогын татварын зардал	1,542,424.70	2,914,264.82
	1,542,424.70	2,914,264.82

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Ажлын гүйцэтгэлд учирч болзошгүй сөрөг нөлөөг багасгахын тулд валютын, хүүгийн хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдахын зэрэгцээ Компанийн хөгжлийг дэмжих санхүүгийн зохистой баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

а) Гадаад валютын эрсдэл

Компанийн гадаад валютын гүйлгээ нь ихэвчлэн төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба төгрөгөөс бусад валютаар хийсэн борлуулалт, худалдан авалтаас үүсэх валютын гүйлгээний томоохон хэмжээний эрсдэл байхгүй. Компани нь өөрийн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хамгийн сайн, боломжит ханшийг хэрэглэх ба орлого, зарлагыг нэг валютаар гүйцэтгэх замаар удирдах бодлогыг барьдаг.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тайлант үеийн байдлаар тус компанийн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь эрсдэлгүй тул гадаад валютын эрсдэлийг үнэлэх мэдрэмжийн шинжилгээ хийдэггүй.

б) Төлбөрийн чадварын эрсдэл

Компани нь өөрийн бүх эргэн төлөлт болон санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа гэдгийг баталгаажуулахын тулд өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал ба санхүүжилтийг идэвхтэй хянаж байдаг. Компани нь өөрийн төлбөрийн чадварын зохистой байдлын ерөнхий удирдлагын нэг хэсэг болгон, өөрийн ажлын капиталын шаардлагуудыг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нэг бүрийн бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоход (эдгээр үнэ цэнийг тооцох нь практик дээр боломжтой бол) дараах арга төсөөллүүдийг ашигладаг.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаат санхүүгийн хэрэглүүр учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

Авлага болон бусад өглөг

Худалдааны зээлийн ердийн нөхцөлд хамрагдах авлага, бусад арилжааны болон бусад өглөгийн дансны үнэ, дансны харьцангуй богино хугацааны шинж чанараас хамааран бодит үнэ цэнтэй ойролцоо утгатай байна.

Холбоотой талуудад өгөх өглөг

Холбоотой талуудад өгөх өглөгүүд нь хугацаагүй буюу хүссэн үед нь төлөх нөхцөлтэй учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

36. КАПИТАЛЫН УДИРДЛАГА

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих, хувь нийлүүлэгчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх явдал юм.